



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/168

Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“а”, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 34.2, 45 дугаар зүйлийн 45.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1, Улсын онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 16 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хархорин, Тарагт, Бат-Өлзий, Арвайхээр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний суудлын автомашин шинэчлэлийн зардалд 20,000,000 (хорин сая), Хужирт сумын Засаг даргын Тамгын газарт албан хэрэгцээний суудлын автомашины худалдаж авах зардалд 12,000,000 (арван хоёр сая), Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газарт албан хэрэгцээний суудлын автомашин худалдаж авах зардалд 6,500,000 (зургаан сая таван зуун мянга), нийт 38,500,000 (гучин найман сая таван зуун мянга) төгрөг нэмэлтээр зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Хархорин, Тарагт, Бат-Өлзий, Арвайхээр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төгрөг сумын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин худалдан авах батлагдсан зардлыг улсын төсвөөс 200,000,000 (хоёр зуун сая), орон нутгийн төсвөөс 35,000,000 (гучин таван сая) нийт 235,000,000 (хоёр зуун гучин таван сая) төгрөг байхаар тооцож гэрээ шууд байгуулах замаар бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулахыг аймгийн Засаг даргын дэрэгдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т зөвшөөрсүгэй.

4.Хужирт, Нарийнтээл сумдын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин худалдан авахад нэмэлтээр батлагдсан зардлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг холбогдох сумын Засаг дарга нарт шилжүүлсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

01110036